



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/806.

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 3.3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд худалдан авсан авто машины үнийн зөрүү 18,000,000 (арван найман сая), Монгол Улсын гавъяат жүжигчин, дуучин Э.Анхбаярт 3,000,000 (гурван сая), дуучин Д.Жавхаасайханд 2,000,000 (хоёр сая) төгрөгийг уралдаан тэмцээнд оролцох арга хэмжээнд тус тус зарцуулсугай.

2. Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд худалдан авсан авто машины үнийн зөрүү 18,000,000 (арван найман сая) төгрөгийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгууллах эрхийг Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчийн Хуралд шилжүүлсүгэй.

3. Дээрх зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101543